



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

Г Дүрэм, чиг үүрэг батлах тухай Г

“Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010-2014 онд хөгжүүлэх бодлого”, ДЭМБ-ын “Сувилахуйн хөгжлийн стратеги”-ийг тус тус хэрэгжүүлэх, сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүргийг нэгдүгээр, Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтын бүдүүвчийг хоёрдугаар, Сувилахуйн албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрмийг гуравдугаар, Сувилахуйн албаны бүтэц, зохион байгуулалтын бүдүүвчийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Сувилахуйн асуудал хариуцсан мэргэжилтэнд өөр чиг үүргийг давхардуулан хариуцуулахгүй байхыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан сувилахуйн албыг 2012 оны 5 дугаар сарын 1-ний дотор шинэчлэн зохион байгуулахыг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, амаржих газар, клиник, сувилал, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн дарга, захирал нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Баярт)-т, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны 132 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...сарын 9-ны өдрийн 195 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн удирдлага,
зохион байгуулалт, үйл ажиллагааны чиг үүрэг

Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн удирдлага нь Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд тус тус шатлан зохион байгуулагдаж, дараах үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

1. Эрүүл мэндийн яамны түвшинд:

1.1 Төрийн захиргааны удирдлагын газарт: Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нөөцийн бодлого, хэрэгжилтийн зохицуулалтыг хариуцсан мэргэжилтэн ажиллах ба салбарын хэмжээнд шаардлагатай сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нөөцийн бодлого, төлөвлөлт, хөгжлийн асуудлыг хариуцан сувилахуйн удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн хөгжил, сургалтын асуудлаар бодлого боловсруулан, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт, ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлж уг асуудлаар харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

1.2 Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт: Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн ажиллах ба сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээнд мөрдөх стандарт, асаргаа, сувилгааны удирдамжийг боловсруулах, хэрэгжилтийг хангах, уг асуудлаар харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

1.3 Эрүүл мэндийн яамны дэргэд орон тооны бус "Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөл" ажиллах ба сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний боловсрол, хөгжил болон тухайн мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, асуудлаар Эрүүл мэндийн яаманд бодлогын зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангахад оролцоно.

2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын түвшинд:

Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нөөцийн болон тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг хариуцсан мэргэжилтэн ажиллаж, аймаг, нийслэлийн хэмжээнд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нөөцийн бодлого, төлөвлөлт, тусламж, үйлчилгээний чанарын талаарх бодлогын хэрэгжилтийг зохицуулж, харьяа эрүүл мэндийн байгууллагуудын сувилахуйн албыг арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3. Эрүүл мэндийн байгууллагын түвшинд


Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны төрөл, зохион байгуулалтаас хамаарч байгууллагын түвшинд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн удирдлага дараах байдлаар зохион байгуулагдана. Үүнд:

3.1 Сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, амаржих газар, сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв нь сувилахуйн албатай байна.

3.2 Сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, амаржих газар, сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тасаг, нэгж болон өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд ахлах сувилагч орон тоогоор ажиллаж нэгжийн болон төвийн хэмжээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн нөөцийн болон тусламж, үйлчилгээний асуудлыг хариуцна.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...4...сарын 9-ны өдрийн 105 тоот
тушаалын хоёрдугаар хавсралт

Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн
удирдлага, зохион байгуулалтын бүдүүвч.



Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...4...сарын 9-ны өдрийн 105 тоот
тушаалын гуравдугаар хавсралт

Сувилахуйн албаны үлгэрчилсэн дүрэм

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Сувилахуйн алба (цаашид "алба" гэх) нь байгууллагын үндсэн зорилго, зорилттой уялдуулан сувилахуйн асуудлаарх бодлого, шийдвэрийг байгууллагын түвшинд хэрэгжүүлэх, сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, хүний нөөцийн хөгжил, төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтыг зохион байгуулах, сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний стандарт, асаргаа, сувилгааны удирдамжийн хэрэгжилтийг хангах, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хөгжил, нийгмийн асуудлыг байгууллагын түвшинд шийдвэрлэх үүрэг бүхий орон тооны бүтэц байна.

1.2 Албаны зорилго нь сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хөгжлийг хангах, сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанар, стандартын мөрдөлтийг сайжруулан, тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэхэд оршино.

1.3 Албыг сувилагч, эх баригч, эмнэлгийн тусгай мэргэжилтний төлөөллийг оролцуулан 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тухайн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирлын тушаалаар байгуулах ба үйл ажиллагааны болон цалин, урамшууллын зардлыг жил бүр байгууллагын төсөвт тусгана.

1.4 Албаны дарга нь сувилахуйн мэргэжилтэн байх ба тухайн байгууллагын захиргааны зөвлөлийн гишүүн байна.

1.5 Алба нь үйл ажиллагаа явуулах тусгай өрөө тасалгаагаар хангагдана.

1.6 Албанд ажиллах арга зүйч сувилагчийн тоо нь тухайн эрүүл мэндийн байгууллагын сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний тооноос хамаарна. Үүнд:

1.6.1 50- 150 бол 2;

1.6.2 150-300 бол 3-4;

1.6.3 300-аас дээш бол 5 хүртэл арга зүйч сувилагчийг ажиллуулж болно.

1.7 Ахлах сувилагч нарт аж ахуйн ажил хавсран хариуцуулахгүй бөгөөд тасгийн аж ахуйн нярав тусдаа орон тоогоор ажиллана.

1.8 Алба нь хүний нөөцийн болон чанарын алба, ёс зүйн хяналтын хороо зэрэг бусад алба, нэгжүүдтэй холбогдох чиг үүргийн дагуу хамтран, үйл ажиллагааны уялдаа холбоог ханган ажиллана.

1.9 Тухайн эрүүл мэндийн байгууллага өөрийн тусламж, үйлчилгээ, зохион байгуулалтын онцлогоос хамаарч бусад тусгай мэргэжлийн албыг тусгайлан байгуулж болно.

Хоёр. Албаны бүрэлдэхүүн, чиг үүрэг

2.1. Алба нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

2.1.1. Албаны дарга (1),

2.1.2. Арга зүйч сувилагч (2-5) ажиллана.

2.1.3. Сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, амаржих газар, сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тасаг, нэгж бүрт болон сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд орон тооны ахлах сувилагч ажиллана. Сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, амаржих газар, сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвд ахлах сувилагч нь сувилахуйн албаны шууд удирдлага дор ажиллана.

2.2. Албаны дарга нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1 Албыг ерөнхий удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.1.2 Байгууллагын түвшинд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээг ерөнхий удирдлагаар хангах;

2.1.3 Байгууллагын түвшинд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нөөцийн хөгжил, сургалт, нийгмийн асуудлыг удирдан зохион байгуулах;

2.1.4 Албаны гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах, хяналт тавих;

2.1.5 Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодын хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх;

2.1.6 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хөдөлмөрийн гэрээний үнэлгээнд оролцох, урамшуулах саналыг гаргах.

2.2 Арга зүйч сувилагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хөгжлийн асуудлыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах;

- 2.2.2 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, судалгаа шинжилгээний талаарх асуудлыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах;
- 2.2.3 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний цалин, урамшуулал, нийгмийн хамгааллын талаарх асуудлыг төлөвлөх, хэрэгжилтийг хангах;
- 2.2.4 Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн гардан үйлдлийн стандарт, асаргаа, сувилгааны удирдамжийн хэрэгжилтийг хангах;
- 2.2.5 Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний чанарын хяналтыг зохион байгуулах
- 2.3 Ахлагч сувилагч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 2.3.1 Сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, амаржих газар, сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тасаг, нэгж, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 2.3.2 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажил үүргийн хуваарийг хариуцан, зохицуулахад эрхлэгч эмчид дэмжлэг үзүүлж ажиллах;
- 2.3.3 Сум дундын эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, клиник, амаржих газар, сувилал, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тасаг, нэгжийн болон өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан, эрхлэгч эмчээр батлуулан хэрэгжүүлэх;
- 2.3.4 Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний стандарт, асаргаа, сувилгааны удирдамжийн өдөр тутмын хэрэгжилтийг хангах.

Гурав. Албаны үйл ажиллагаа

3.1 Сувилахуйн тусламж, үйлчилгээтэй холбоотой хууль, журмын хэрэгжилтийг хангах талаар:

- 3.1.1 Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж болон Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газрын шийдвэр, өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангах, холбогдох мэдээ, тайланг зохих хугацаанд нь хүргүүлэх;

- 3.1.2 Байгууллагаас зохион байгуулж буй олон талт ажил, аливаа шийдвэрийг хамт олонд мэдээлэх, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах,
- 3.1.3 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг мэргэжлийн болон ёс зүйн алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх.
- 3.2 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хүний нөөцийн хөгжлийн асуудлаар:
- 3.2.1 Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн хүний нөөцийн бүрдэлт, сувилахуйн хөгжлийг хангах асуудлаарх үйл ажиллагааг байгууллагын түвшинд хариуцах;
- 3.2.2 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтын төлөвлөгөө гаргах, судалгаа шинжилгээний ажил хийхэд нь дэмжлэг үзүүлэх;
- 3.2.3 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн баталгааг сайжруулах стратеги, хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлэхэд холбогдох албатай хамтран ажиллах;
- 3.2.4 Байгууллагын хэмжээнд ажиллаж буй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний хувийн хэрэг, бүртгэлийг хариуцан жил бүр баяжилт хийж байх;
- 3.2.5 Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллежийг сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжлээр төгсч ирж буй шинэ мэргэжилтэнг ажлын байран дээр дадлагажуулах сургалтыг зохион байгуулах;
- 3.2.6 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний мэргэжлийн ур чадварт үнэлгээ өгөх, урамшууллын багцыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 3.2.7 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх цогц арга хэмжээ авах, хууль эрх зүйн мэдээллээр хангах;
- 3.2.8 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэжлийн зэрэг горилох, ахиулахад бэлтгэх, судалгаа хийж ажиллах.
- 3.3 Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний асуудлаар:
- 3.3.1 Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

- 3.3.2 Байгууллагын хэмжээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, шалган зааварлах, гүйцэтгэлд хяналт тавих;
- 3.3.3 Байгууллагын хэмжээнд сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан арга хэмжээ авч ажиллах;
- 3.3.4 Сувилахуйн үйл ажиллагаанд хөтлөгдөх анхан шатны бүртгэлийн маягыг хөтөлж, хэрэгжүүлэх, хяналт тавих, шинэчлэн боловсруулах;
- 3.3.5 Хүн амд үзүүлэх сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламжийн шинэлэг хэлбэрүүдийг өргөтгөн хөгжүүлэх;
- 3.3.6 Нотолгоонд тулгуурласан үр дүнг тооцон ажиллах;
- 3.3.7 Сувилахуйн чиглэлээр аргачлал, удирдамж, шинэчлэн боловсруулах;
- 3.3.8 Үйлчлүүлэгч, хамт олны сувилахуйн үйлчилгээний сэтгэл ханамжинд улирал тутам дүгнэлт хийж ажиллах.

Дөрөв. Албаны үйл ажиллагааны хяналт, үнэлгээ


- 4.1 Алба нь үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрийн хяналт, биелэлтийг хамт олноор хэлэлцүүлэн дүгнэлт өгч ажиллана.
- 4.2 Алба нь үйл ажиллагааны тайланг улирал бүр албаны хурлаар хэлэлцэн, байгууллагын захиргааны зөвлөлийн хуралд тайлагнана.
- 4.3 Албаны дарга нь сувилахуйн албаны жилийн эцсийн тайланг харьяалагдах Эрүүл мэндийн газарт жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор, Эрүүл мэндийн газар нь харьяа эрүүл мэндийн байгууллагуудын сувилахуйн албаны тайланг хянан, нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлнэ.
- 4.4 Эрүүл мэндийн яам болон тухайн байгууллагаас албаны үйл ажиллагаанд шаардлагатай үед хөндлөнгийн хяналт хийлгэж болно.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...сарын 9-ны өдрийн 105 тоот
тушаалын дөрөвдүгээр хавсралт

Сувилахуйн албаны бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч

Бүдүүвч - 1

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, клиник, амаржих газар, сувилалын сувилахуйн албаны бүтэц, зохион байгуулалтын үлгэрчилсэн.



Бүдүүвч – 2

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн удирдлагын үлгэрчилсэн загвар.

